



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 67

Эрдэнэт

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Төр сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулах журмын 3.3, 3.4-д заасныг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Холбогдох материалыг бүрдүүлэн ирүүлж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохыг хүссэн “Тэнгэрлэг Нигүүлсэл” католик сүм, “Мөнхийн зул” дацан шашны байгууллагуудад үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тус бүр 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Хууль тогтоомж, дүрмийнхээ дагуу үйл ажиллагаа явуулах, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэж байх, жил бүрийн тогтоосон хугацаанд үйл ажиллагааны тайлангаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд албан ёсоор ирүүлж байхыг “Тэнгэрлэг Нигүүлсэл” католик сүм, “Мөнхийн зул” дацангийн удирдлагад үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МЯГМАРСҮРЭН